



БОГД БАНКНЫ ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Д.МОЛОМЖАМЦЫН 2021 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Монголын эдийн засагт, түүний дотор бизнесийн үйл ажиллагаанд цар тахалын сөрөг үр дагавар ихээхэн нөлөөлж байгаа хэдий ч Богд банкны удирдлагын зүгээс энэ хүнд нөхцөлд банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах тусгай төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд Банкны уйл ажиллагаа 2021 онд нэг их доголдолгүй явж ирсэн гэж хэлж болно. Мэдээжийн хэрэг цар тахалын улмаас банкны уйл ажиллагааг тэлэх талаар төлөвлөсөн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх боломж гараагүй нь ойлгомжтой. Богд банк Монгол улсын зах зээл дээр багагүй үүрэг гүйцэтгэн улсын эдийн засагт хөрөнгө оруулалт хийж, харилцагчийн шаардлагыг хангасан банкны үйлчилгээ үзүүлж байна.

Богд банк 2021 оны 12 сарын 31-ний байдлаар 10 салбар нэгжтэй ажиллаж, тэдгээрт 170 гаруй хүн хөдөлмөрлөж байна. Харилцагчдын тоо ч нэмэгдэж байна. Богд банк 53 мянга гаруй харилцагчтай болсон оны эхнээс найман мянгаар нэмэгдсэн байна.

Богд банк нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны гол үзүүлэлтийг ханган ажиллаж байна. Богд банк нь банкны салбарын анхдагч нээлттэй хувьцаат компанийн статус бүхий арилжааны банк болох зорилгоо амжилтай хэрэгжүүлж, 12,500,000 ширхэг үнэт цаас гарган борлуулж чадсан байна. Үүний үр дүнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 100 000 000 000,00 төгрөг болж, оны эхнээс хоёр дахин нэмэгдэж, энэ талаар Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг биелүүлж байна. Банкны актив хөрөнгө 2021 оны 12 сарын 31-ны байдлаар 327 052 219 785,07 төгрөг болж, мөн оны эхнээс 47 хувиар өссөн байна.

Мөн Банкны нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 101 551 810 732,26 төгрөг байгаа нь энэ оны эхнээс 65 хувиар өсчээ.

МОНГОЛ БАНКНААС ТОГТООСОН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Биелэлт
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа	>9%	49,58%
Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	49,58%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт	>20%	45,19%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	<±15%	5,65%
Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)	<±30%	6,13%



Монголбанкнаас тогтоосон шалгуур гол үзүүлэлтүүд, тухайлбал, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө ба эрсдэлээр жигнэсэн активын харьцаа нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна. Банкны зээлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, зээлийн чанар өнгөрсөн оноос сайжирсан байна.

2021 оны 2 дугаар хагас жилд болсон ТУЗ-ийн бүх хурал зайнаас оролцож хараат бус гишүүний хувьд өөрийн байр суурийг илэрхийлж байсан болно. Мөн 2021 оны 2 дугаар хагас жилд Эрсдэлийн хороо 1 удаа, Аудитын хороо 4 удаа, Урамшуулалын хороо 1 удаа хуралдсан байна. Эдгээр хурлуудаар банкны үйл ажиллагааны олон талт асуудлыг зохих журмын дагуу хэлэлцэж, зохих шийдвэрийг гаргаж ирсэн байна.

Хараат бус гишүүний чиг үүргийн дагуу эрсдэлийн болон санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр холбогдох нэгжүүдтэй ойрхон ажиллаж, энэ чиглэлээр ТУЗ болон Банкны удирдлагад зөвлөмж өгч ажиллаж байна. Монголын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн тогтвортой бус байдлаас улбаалж, цаашид банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох эрсдлийг тогтоож, сэрэмжлэх арга хэмжээ авахад Банкны удирдлагад туслахад ТУЗ-ийн хараат бус гишүүний үүргийн хүрээнд анхаарч байна.

Компанийн тухай хуульд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож санал өгч ажилласан болно. Мөн Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэрийг ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын зүгээс гаргаагүй болно.

БОГД Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2022.01.18

Д.Моломжамц